

Доктор (Ph.D), МУИС-ийн профессор Т.ДОРЖДАГВА  
МУИС-ийн Философийн тэнхмийн эрхлэгч

## СОЁЛ СУДЛАЛЫН КАТЕГОРИУДЫГ ШИНЖИХ НЬ

Ойлголт нь бидний сэтгэхүйн нэг хэлбэр мөн бөгөөд вербаль, вербаль бус, паравербаль аль нэгэн аргаар илэрхийлэгдэж, бусдад хүрдэг байна. Мэдлэгийн аливаа салбар өөрийн өвөрмөц ойлголтуудтай байдаг ба тэр ойлголтуудын дотроос хамгийн үндсэн гэж хэлж болохуйц, тухайн мэдлэгийн агуулгыг нээн илрүүлж чадах хэрэгсэл болсон тулгуур ойлголтыг категори гэдэг. Шинжлэх ухааны салбар бүр өөрийн гэсэн категоритой, тухайлбал: биологид амь, бодисын солилцоо, удамшил, хувьсал; цахилгааны физикт цэнэг, ампер, ватт; эдийн засагт үйлдвэрлэл, хувиарлалт, арилжаа; урлаг судлалд уран бүтээл, уран бүтээлчийн чадвар, уран сайхны үйл ажиллагаа; анагаах ухаанд эрүүл болон эмгэг гэхчлэн категори хэрэглэдэг байх жишээтэй.

Соёл судлалын шинжлэх ухаан өнөөдөр хүмүүнлэгийн нийт шинжлэх ухааны удиртгал болж, тэдгээрийн суурь ойлголтыг боловсруулах хүндтэй үүргийг улам бүр хүлээх болсныхоо хэрээр бусдаас хавьгүй өргөн цар хүрээтэй, олон тооны категори болговсруулан буй болгож байна. Тийм учраас тодорхой нэг цаг хугацааны давтамжтайгаар тэдгээрт анхаарал хандуулан, нийгэм, хүмүүнлэгийн ухааны мэргэжлийн хүмүүс, эрдэмтэд, судлаачид тогтмол зөвлөлдөн мэтгэлцэж, зарим нэр томъёог зөвшилцөн тогтоож, хэвшүүлэн хэрэглэж байгууштай байна.

Гадаадад хэвлэгдсэн зарим бүтээлд уг асуудлыг хэрхэн авч үзэж, шийдвэрлэж байгааг юуны түрүүнд энд дэлгэн толилуулья. Тэгэхдээ бидэнд янз бүрийн сургууль, мэргэжлийн онцлог, сургалтын өөр өөр зориулалтаас шалтгаалан соёл судлалын чиглэлийн дагуу үй олон тоо ширхэгээр бичиж хэвлүүлсэн бүтээл тэр болгоныг авч үзэх бололцоо олдоогүй бөгөөд харин хангалттай тооны сурах бичиг, гарын авлага, толь бичгүүдийг сөхөж үзэхдээ “соёл судлалын үндсэн ойлголтууд”, “соёл судлалын категориуд” гэсэн гарчиг, сэдвийг онцлон хайж, баримт болгон энд оруулсанаа хүлцэн тэмдэглэе.

Профессор Драч Г.В. нарын хамтын зохиогчтой 2003 онд Ростов на Дону-д хэвлэгдсэн “Соёл судлал. Лекцийн тэмдэглэл” хэмээх нэртэй авсаархан нэгэн гарын авлагын 4 дүгээр лекцийг “Соёл судлалын категориуд” хэмээн нэрлээд түүнд:

1. Ертөнцийн тухай соёлын дүр зураг



---

2. Соёлын хэм хэмжээ ба үнэлэмж

3. Тэмдэг ба бэлгэдэл

4. Соёлын утга, код, универсаль гэсэн дэд сэдвүүдийг /1. 26-36/ зориуд гарчиглан оруулсан бол судлаач Б.И.Кононенко 2002 онд Москвад хэвлүүлсэн “Соёл судлалын үндэс” номондоо “Соёл судлалын үндсэн ойлголт, категориуд” гэдэг гарчигийн дотор /2 . 16-19/:

1. Соёл

2. Иргэншил

3. Соёлын артефакт

4. Соёлын институт

5. Аж төрөх ёс

6. Соёлын морфологи

7. Соёлын хүн судлал

8. Философийн хүн судлал

9. Соёлын хэл

10. Жам ёсны хэл

- Зохиомол хэл

- Мета хэл

- Хоёрдогч хэл

- Урлагийн хэл

11. Бэлгэдэл

12. Соёлын код

13. Хэм хэмжээ

14. Үнэлэмж

15. Уламжлал

16. Соёлын өөртэйгөө ижил байхуй

17. Соёлын өөрийн ухамсар

зэргийг тодотгосон үсгээр бичиж, тэдгээрт дор бүрт нь товч тайлбар өгсөн байна. Тэгвэл К.М.Хорушенко 1997 онд бичиж биеэ даан гаргасан “Соёл судлал. Нэвтэрхий толь”-доо “Соёл судлалын категориуд” гэсэн нэрийн дор:

1. Соёл

2. Соёлын үнэлэмж



3. Соёлын субъект
4. Соёлын өв
5. Соёлын уламжлал
6. Соёл дахь шинэчлэл
7. Соёл ба нийгэм
8. Соёлын социодинамик
9. Соёл ба иргэншил

сэлтийг хамааруулсан байдаг /6. 197/. Бас нэг зохиогчийн бүтээлийг энд зориуд онцлон тэмдэглэх нь зүйтэй байх. Яагаад гэвэл энэ нь бусдаасаа харьцангуй ялгаатай байгаа юм. Судлаач В.И.Полищук 1999 онд Москвад хэвлүүлсэн "Соёл судлал"-ын гарын авлагынхаа "Соёлын төрөл, хэлбэр, агуулга, функци" гэсэн 2 дахь сэдэвтээ:

1. Соёлын төрөл
2. Соёлын хэлбэр
3. Соёлын агуулга
4. Соёлын функци

зэргийг хэд хэдэн тусгаар сэдвүүдэд багтаан тайлбарлаж /5. 24-41/, харин "Соёлын бүтэц" гэж нэрлэсэн 3 дахь сэдэвтээ /5. 42-63/:

5. Соёлын төвшин
6. Соёл ба иргэншил
7. Гадаад ба дотоод соёл, тэдгээрийн харилцаа холбоо болон харилцан өөрчлөлт
8. Соёлын баримжаалал
9. Байгалийн зүйл ба хүний зүйл
10. Тэнгэрлэг зүйл ба газар дэлхийн зүйл
11. Рациональ зүйл ба сэтгэл хөдлөлийн зүйл
12. Соёлуудын яриа хэлцээ
13. Соёл дахь хэмжүүр болон баримжаалалын бүдүүвч
14. Соёлын хэм хэмжээ, үлгэр загвар, заншил
15. Уламжлал соёл судлалын үндсэн ойлголт болох нь
16. Заншил, ёс заншил, ёслол зэрэг нь уламжлалын эгшингүүд болох нь
17. Уламжлалт нийгэм



18. Соёл ба бүтээл
19. Соёл дахь ангийн ба нийт хүн төрөлхтний зүйл
20. Соёл дахь үндэсний ба интернациональ зүйл
21. Хэрэгцээ ба соёлын хөгжилд тэдгээрийн гүйцэтгэх үүрэг
22. Нийгмийн институт нь соёлыг зохион байгуулах арга болох нь
23. Соёлын үнэлэмжийн эрэмбэлэл

гэсэн нэртэй олон товч тайлбаруудыг багтаажээ.

Тэгвэл өөр нэг бүтээлд уг асуудлыг нэн дэлгэрэнгүй болгон авч үзсэн байх боловч, тусгаар категори бүрт тодорхой тайлбар өгөөгүй байсан болно. Санкт-Петербургт 1997 онд хэвлэгдсэн “Соёл судлал. XX зуун. Толь бичиг” бүтээлд соёл судлалд илүү дэлгэрмэл хэрэглэгдэж байдаг категориудыг дараахи байдлаар цувуулан тэмдэглэжээ:

1. Соёлын объект (соёлын шинж, артефакт, бодослог хийгээд бэлгэдлийн илэрхийлэл дэх тэдгээрийн хэлбэр, соёлын зохиомж, хэлбэр дүрс, тогтолцоо, эцэст нь пан соёл бүхэлдээ);
2. Соёлын үйл явц (соёлын гарваль, төлөвшил, үйл ажиллагаа, дэлгэрэхүй, хувьсал, нөхөн үйлдвэрлэл гэх мэт);
3. Соёлын шинж (функциональ чанар, утгат чанар, дахин ашиглагдах чанар, харилцаан чанар, үнэлэмж, технологи чанар, универсаль чанар, байршилт чанар, ховор нандин чанар, нийтлэг чанар гэх зэрэг);
4. Соёлын функци (нийгэм-соёлын зохион байгуулалт ба зохицуулалт, хүрээлэн буй ертөнцийг танин мэдэхүй, нийгмийн туршлагыг хуримтлуулах, сонгох, дамжуулах, мэдээлэл солилцох гэх мэт);
5. Соёлын модаль чанар (эволюци, шинэчлэл, дэвшил, доройтол, бүтцийг эвдэхүй, циклизм);
6. Соёлын утга холбогдол (үзэгдлийн соёлын утга, үнэлгээ ба үнэлэх шалгуур, соёлын герменевтик);
7. Соёлын тэмдэглэгээ (тэмдэг, бэлгэдэл, дүр, тэмдэглэгээ, салшгүй гол шинж, имиж, утга бүхий бүтээц, соёлын сэдэв, код, тэмдгийн гарал, соёлын семантик бүхэлдээ);



8. Соёлын үнэлэмж (аж байдлын, материаллаг, дурсгалт, уран сайхны, үзэл суртлын, зан суртахууны, шашны, нийгмийн баялаг, экзистенциаль баримжаалал гэх мэт);

9. Соёлын хэм хэмжээ (үлгэр загвар, үлгэрлэл, дүрэм, стандарт, горим жаяг, уламжлал, ёс суртахуун, ёс зүй, гоо зүй, хийц маяг, моод, функцит илрэлийн хэм хэмжээт чанар, хөдөлмөр болон хэрэглээний, ахуй болон чөлөөт цагийн, харилцаа болон харилцан үйлчлэлийн гэх мэт соёл); 0

10. Соёлын орчин (амьдралын үйл ажиллагааны юмс-орон зайн зохиомол орчин болох соёлжсон газар нутаг, хүн ам бүхий цэг, барилга байгууламж, орон байр, эд юмс болон үйл ажиллагааны материаллаг бусад бүтээгдэхүүн, хүмүүсийн ердийн амьдрал болон үйл ажиллагааны тусгай салбар дахь харилцан үйлчлэлийн нийгэм-мэдээллийн орчин);

11. Соёлын субъектүүд ба тэдгээрийн тогтвортой хамт олон (бие хүн, гэр бүл, ураг төрлийн омог, нийгмийн функциональ бүлэг ба хамт олон, анги, каст, язгуур, социум, нийгэмлэг, нийгмийн организм, угсаатан, үндэстэн, хүн төрөлхтөн);

12. Бодгаль соёлыг эзэмших үйл явц ба үр дүн (нийгэмшил ба инкультураци, соёл уусахуй ба аккумуляраци, хүмүүжил ба сургалт, нийгэм соёлын өвч адил ба ялгаатай байдал);

13. Соёлын сэдэлт (хувийн ба бүлгийн ашиг сонирхол, хэрэгцээ, зайлшгүй байдал, дасан зохицохуй, зорилго тавих, өөрийгөө зохион байгуулахуй ба өөрийгөө зохицуулахуй, өөртэйгөө ижил байхуй ба өөрийгөө таниулан тэмдэглэхүй, бие хүний нийгэмд гүйцэтгэх үүрэг ба функци, статус, өсөх чадвар, "хамтын ухамсарт бус зүйл" гэх мэт);

14. Соёлоор нөхцөлдсөн зан үйл ба хүмүүсийн ухамсар (зорилтот үйл ажиллагаа ба харилцан үйлчлэлийн технологи, ёслолын зан үйл, ёс заншил ба бэлгэдлийн ёслол, хэлэхүйн ба хэлэхүйн бус харилцаа, бүтээл ба шинэчлэл, аж төрөх ёс ба чөлөөт цаг, ертөнцийг төсөөлөхөй, домог зүй ба сүсэглэл, сэтгэлгээний онцлог, ухамсрын анхдагч илрэл зэрэг);

15. Үйл ажиллагааны тусгай салбаруудын соёлын аспект (аж ахуйн, эрхийн, улс төрийн, цэргийн, философийн, шашны, уран сайхны, шинжлэх ухааны, боловсролын, мэдээллийн, байгалийг ашиглах, эрүүл мэндийг хамгаалах, нөхөн



---

үйлдвэрлэлийн, хүмүүсийн хөгжил болон цагаатгах соёл, тэрчлэн ерийн амьдралын хүрээн дэх тэдгээрийг орлох адил зүйл);

16. Соёлын институт (соёлын бодлого, соёл болон чөлөөт цагийн, боловсролын болон нийгмийн хамгааллын байгууллага, бүтээлч зохион байгуулалт, өвийг хамгаалах болон мэдээллийг хуримтлуулах газар, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл гэх мэт);

17. Соёлын нэгдэх, ялгарах үйл явц, үзэгдлүүд (хоршилт, нягтрал, эв нэгдэл, социаль чанар, ёс зүйт чанар, харилцан туслалцах, өөрийн онцлог, байршилт чанар, функцийн хуварилалт, ачааллыг ихэсгэх ба бууруулах гэх мэт);

18. Соёлын нийгмийн хэв маягчлал (тусгай ба ердийн, элит ба ард түмний, хялбар дэлгэрмэл ба нийтийн соёл, нийгмийн давхраажилын дэд соёл, аж төрөх ёс гэх мэт);

19. Соёл-түүхийн хэв маягчилал (угсаатаны болон нийгмийн нийгэмлэг, төр улс, бүс нутгийн соёлын нийтлэг, иргэншил, хүй нэгдлийн, архайн, аж үйлдвэржихийн өмнөх, аж үйлдвэржих, аж үйлдвэржсэний дараахи зэрэг нийгэм-соёлын зохион байгуулалтын түүх-үе шатчилалын хэв маягуудын соёлын өвөрмөц байдал);

20. Соёл хоорондын харилцан үйлчлэл (соёлын нэвчилт, зээлдэлт, тэвчээр, харилцан биенийгээ нөхөхүй, дээрэмдэн авахуй, үнэлэмжийн мөргөлдөөн, соёлын синтез, хиллэж байгаа улс орон гэх мэт) зэргийг оруулжээ. Тэрчлэн бас нэгжээд шинжтэй ийм категориудыг тоочиж болох юм гэж тэмдэглэсэн байна /3. 182-185/.

Бас яг ийм ангилалд мэр сэр засвар хийгээд Л.Д.Столяренко нарын зэрэг олон зохиогчтойгоор 2004 онд Ростов на Дону хотноо хэвлүүлсэн “Соёл судлал: Шалгалтын 100 хариулт” гарын авлагад /4. 67-69/ толилуулсан байдаг.

Харин аль ч бүтээлд категориудыг дугаарлаагүй байсан болохыг цохон тэмдэглэхийн хамт, тэдгээрийг ийнхүү босоогоор цувуулан байрлуулж, дугаарласан нь уншигчдийн анхаарлыг зориуд татах, ойлголт, категориудыг тоо хэмжээ, агуулгын хувьд харцуулан үзүүлэх гэснээс өөр зорилго байхгүй болохыг болгооно уу. Мөн дээрх материалыг дэлгэрэнгүй оруулахын учир юун гэвэл шинэ тутам хөгжин түгэж байгаа мэдлэгийн энэхүү салбарын агуулгыг түмэн нийтэд хүргэх танин мэдэхүйн зорилго өвөрлөсөнөө нуух хэрэггүй биз ээ.

Зарим дүгнэлтийг хийж үзвэл:



- Соёл судлалыг аливаа бусад шинжлэх ухаан, түүний дотор хүмүүнлэгийн шинжлэх ухаануудтай жишэж үзвэл тэдгээрээс харьцангуй олон ойлголт, категориудтай байна.
- Нөгөө талаар зарим нэг ойлголт, категориуд, тухайлбал, соёл, үнэлэмж, хэм хэмжээ, чин эрмэлзлэл, уламжлал, тэмдэг, бэлгэдэл, утга, хэл, иргэншил, заншил, зан үйл, ёслол, бэлгэдэх ёслол, зуршил, соёлын институт, соёлын субъект, соёлын функци болон соёлыг хэв маягчлах асуудал зэрэг нь бусдаас илүү давтамжтай байгаа нь ажиглагдаж байна.
- Соёл судлалын категориудыг нийгэм-хүмүүнлэгийн аль ч шинжлэх ухаанд өргөн ашиглаж хэрэглэх бүрэн бололцоотой юм. Энэ утгаараа соёл судлал нь бусад тодорхой шинжлэх ухаануудтай харьцуулбал илүү мета онол болох бөгөөд дунд шатны эргэцүүлэл болдог гэж үзэж болох юм.
- Соёл судлалын категориудыг олон шинжлэх ухааны мэдлэгийн чадавхийг дайчилах үндсэн дээр цаашид илүү нарийвчлан тогтоох шаардлага зүй ёсоор урган гарч байна.

#### НОМ ЗҮЙ

1. Драч Г.В. и др. Культурология. Конспект лекций. – Ростов н/Д, 2003. – 160 с.
2. Кононенко Б.И. Основы культурологии: Курс лекций. – М.: ИНФРА-М; 2002. – 208 с.
3. Культурология. XX век. Словарь. – Санкт-Петербург. – Университетская книга, 1997. – 640 с.
4. Культурология: 100 экзаменационных ответов: Учебное пособие. – Москва: ИКЦ "МарТ", Ростов н/Д: Издательский центр "МарТ", 2004. – 256 с.
5. Полищук В.И. Культурология: Учебное пособие. – М.: Гардарики, 1999. – 446 с.
6. Хоруженко К.М. Культурология. Энциклопедический словарь. – Ростов –на-Дону: Изд-во "Феникс", 1997. – 640 с.